



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/160

Улаанбаатар хот

**Дүүргийн нутаг дэвсгэрт хариулгагүй  
гахай бэлчээхийг хориглох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.5 дэх хэсэг, Эрүүл ахуйн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Суурьшлын бүсэд гахайг хариулгагүй бэлчээснээс иргэдийн амьдрах орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл учирч байгаа тул цаашид нийгэмд үүсэж болох сөрөг үр дагавар, мал амьтны гоц халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт хариулгагүй гахай бэлчээхийг хориглосугай.

2.Өөрийн эзэмшил, өмчлөлд байгаа гахайг тэмдэгжүүлж таних тэмдэгтэй болгох талаар иргэдийг мэдээ мэдээллээр хангах, цаашид харьяалах нутаг дэвсгэртээ хариулгагүй гахай бэлчээж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт, Багахангай Тохижилт ОНӨААТҮГ (Б.Гэрэлмаа)-т үүрэг болгосугай.

3.Зөрчил гаргасан иргэдэд мэдэгдэл хүргүүлж, зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг мал эмнэлгийн тасаг (Я.Батсүх)-т үүрэг болгосугай.

4 Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД